

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА
.....О.ЧИНЗОРИГ



БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хариуцах хэлтэс нэгж
Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1.1	АТГ-аас хэвлэсэн бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх	Жилд	Байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан байх	Авлигын эсрэг хуулийг иргэд, олон нийтэд олон эх үүсвэрээр хүргэнэ.	ЗТСХ
1.2	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Жилд	Дэмжиж хамтран ажилласан байх	Авлигын эсрэг үйл ажиллагаанд бүх түвшинд дэмжин оролцсон байна.	ЗТСХ ТСХХ ТХЗХ
Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах					
2.1	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Авлигаас урьдчилан сэргийлэх чилэлийн	ЗТСХ

2.2	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	мэдлэг мэдээллээр хангагдана.	ЗТСХ
Зорилго 3: Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх					
3.1	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Тухай бүр	Арга хэмжээг хэрэгжүүлсэн хариу тайланг хүргүүлсэн байх	Зөвлөмжийн хэрэгжилтийг 100% ханган ажиллана.	ЗТСХ ТСХХ ДБТХХ ТХЗХ
3.2	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Тухай бүр	Арга хэмжээг хэрэгжүүлсэн хариу тайланг хүргүүлсэн байх	Зөрчилгүй байна.	ЗТСХ ТСХХ ДБТХХ ТХЗХ
Зорилго 5. Авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах					
5.1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх гэх мэт/	Жилдээ	Үйлчилгээг цахимжуулсан байх	Орон зай цаг хугацаанаас үл хамааран төрийн үйлчилгээг авдаг болно.	ТСХХ ДБТХХ ТХЗХ
5.2	Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас үзүүлж буй согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлүүдийг болон барилга байгууламжтай холбоотой 100 гаруй үйлчилгээг бүрэн цахимжуулах "Онлайн бизнэс төв"-ийн II-р шатны хөгжүүлэлт	3-р улиралд	Цахимжуулсан үйлчилгээний тоо	Төрийн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдэнэ.	ТСХХ ДБТХХ ТХЗХ
5.3	Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр хураах цэгийг цахимжуулах	3-р улиралд	Цахимжуулсан төлбөр хураах цэгийн тоо	Авто зам ашигласны төлбөр, хураамжийг цахимаар төлөх боломжтой болно.	ТСХХ ТХЗХ
Зорилго 6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах					
6.1		Сар бүр	Ил тод нээлттэй байршуулсан байх	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж	ЗТСХ ТХЗХ

<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах</p>			<p>байгаа төсөл арга хэмжээний мэдээлэлтэй нээлттэй танилцах боломжтой болно.</p>	
--	--	--	---	--

БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот


Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хувь
1	АТГ-аас хэвлэсэн бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх	Авлигатай тэмцэх газраас гаргасан уриалга, зурагт хуудас, гарын авлага зэргийг байгууллагын албан хаагчдад танилцуулан мэдээлллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэж ажилласан бөгөөд АТГ-ын цахим хуудсанд нийтлэгдсэн теле зохиомж, хөдөлгөөнт зураг, тв шторк, авилгалын эсрэг теле зохиомжуудын нийтлэлийг иргэдэд ил тод нээлттэй байдлаар хүргэх асуудлаар байгууллагын цахим хуудаст нийтлэх ажлыг зохион байгуулсан.	70%
2	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа бүхий л арга хэмжээг байгууллагын хэмжээнд дэмжин хамтран ажилладаг бөгөөд уриалга, зурагт хуудас, гарын авлага зэргийг байгууллагын албан хаагчдад танилцуулан мэдээлллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэж ажилласан.	70%
3	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх	Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагын албан хаагчдад зориулан анхан, давтан, мэргэшүүлэх чиглэлээр авлигын эсрэг сургалтыг зохион байгуулдаг анхан шатны сургалтад байгууллагын хэмжээнд төрийн албанд шинээр томилогдсон 2 албан хаагчийг хамруулсан бөгөөд авлигын ойлголт, мэдлэг өгөх, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, харилцааны талаарх агуулга бүхий цогц мэдлэгийг сургалтаар олж авсан.	70%
4	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх	Авлигатай тэмцэх газраас АТГ-ын мэдүүлгийн https://meduuleg.iaac.mn/ цахим системийг шинэчлээд байгаа бөгөөд уг системийн шинэчлэлтэй холбоотой мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) нарт зориулсан цахим сургалт болон НЗДТГ-аас зохион байгуулсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг	70%

		бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтуудад тухай бүр нь хамрагдсан.	
5	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%
6	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Байгууллагын хэмжээнд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Зөрчил арилгуулах албан бичиг ирээгүй болно.	70%
7	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх гэх мэт/	Онлайн бизнес төвийн 2-р шатны хөгжүүлэлтээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж буй 108 үйлчилгээг цахимжуулахаар ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас олгодог Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох болон галын дүгнэлт олгох үйлчилгээг нэн тэргүүнд буюу 10 дугаар сарын 28-ны дотор хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ. Үүний дараа барилгын үйл ажиллагаатай холбоотой 70 гаруй үйлчилгээнүүдийн цахимжуулна. Системийн ажлын явц 30 хувьтай явагдаж байгаа ба төслийн менежментийн ажлууд бүрэн хийдэж дууссан. Үүнд: Системийн судалгаа, хэрэглэгчийн шаардлага тодорхойлох процессыг баталгаажуулах, Текник сервер тоног төхөөрөмжийн үзүүлэлт боловсруулах, ерөнхий бүтэц, архитектур, дэлгэцийн зураг боловсруулан хэрэгжүүлэх шийдэл гаргах, өөрчлөлтүүдийг тусгах гэх мэт. Системийн хөгжүүлэлтийн ажил явагдаж байна	30%
8	Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас үзүүлж буй согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлүүдийг болон барилга байгууламжтай холбоотой 100 гаруй үйлчилгээг бүрэн цахимжуулах "Онлайн бизнэс төв"-ийн II-р шатны хөгжүүлэлт		
9	Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр хураах цэгийг цахимжуулах	Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодыг цахимжуулах төлбөрийн цахим систем нэвтрүүлэх туршилтын ажил хийгдэж байгаа бөгөөд цахим төлбөрийн системд дараах төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлээд байна. Үүнд: 1. Цахим төлбөрийн и-баримтын буцаан олголтоос суутгах;	70%


		<p>2. Арилжааны банкуудын аппликэйшнд нэхэмжлэх үүсгэн төлөх;</p> <p>3. Тээврийн хэрэгслийн үйлчилгээний нэгдсэн https://smartcar.mn/ системд нэхэмжлэх үүсгэж дараа төлбөрт байдлаар гэх мэт цаашид тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт сонголт бий болгох үүднээс бусад цахим төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Мөн Налайх дүүргийн тэрэлж, Сонгинохайрхан дүүргийн баруун туруун төлбөр авах цэгүүдэд төлбөрийн систем нэвтрүүлэх туршилтыг амжилттай гүйцэтгэн ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Нийслэлийн товчоодын төлбөр авах цэгүүдэд төлбөрийн систем нэвтрүүлэх туршилтын ажил хийгдэж дууссан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>	
10	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүгийн чиглэлийн мэдээллийг тухай бүр, сар бүрийн 08-ны дотор цаг хугацаанд нь нээлттэй мэдээлж ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсөв гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн тайлан, цалингийн зардал, хандив тусламж төсөвт байгууллагын батлагдсан төсөв, зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагаанаас олсон орлого, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт зэрэг 9 төрлийн мэдээлэл хөрөнгө оруулалт тендертэй холбоотой хөрөнгийн зардал, тендерийн ерөнхий мэдээлэл, 5 саяаас дээш худалдан авалтын мэдээлэл тус тус шилэн дансны системд оруулсан. 2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.mn цахим хуудсанд Байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн 	70%

		<p>болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүсээгүй болох зэрэг мэдээ мэдээллийг сар бүрийн 07-ны дотор шилэн дансанд оруулан хавсаргах материалыг PDF файлаар хөрвүүлэн нээлттэй мэдээлсэн.</p>	
<p>Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 дугаар улирлын хэрэгжилтийн дундаж хувь:</p>			<p>65.5%</p>

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.САЙНХҮҮ

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Г.ЭНХЗУЛ